

ОТРООР ОРЖ ИРСЭН МАЛЧИН ИРГЭДТЭЙ УУЛЗАЖ,
БЭЛЧЭЭР ЧӨЛӨӨЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

2020.02.04

Сэвхүүл

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 2020 оны 1 дугаар сарын 20-ны өдөр сумын нутаг дэвгэрт гаднаас отроор орж ирсэн малчин иргэдтэй уулзаж, бэлчээрийг чөлөөж нүүх албан мэдэгдэлийг танилцууллаа. Бэлчээрийг 3 хоногийн хугацаанд чөлөөлөх албан мэдэгдэл өгч, малын гоц халдварт өвчний вакцин тарилга хийлгэсэн эсэх малын эрүүл мэндийн дэвтэр зэргийг үзэж шалгасан байна. Сумын нутаг дэвгэрт гадны аймаг сумаас 10 өрхийн 6857 тоо толгой мал оторлож байна.



Үүнээс гадна өөрийн өвөлжөө хаваржааны газарт дур мэдэн гадын айл өрхийг буулгасан сумын малчин өрхүүдийн өвөлжөө хаваржааны доорхи газрын газар эзэмших эрхийг гэрчилгээг хүчингүй болгох, гадны айл өрх өвөлжөө хаваржаандаа буулгахгүй байх талаар албан мэдэгдэл өгч танилцуулга арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Манай сумаас гадны аймаг, сумдад 27 өрхийн 7464 тоо толгой мал оторлож байна.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР